

МОНГОЛ, ХЯТАДЫН ХИЛИЙГ ШАЛГАХАД ОРОЛЦСОН ТУХАЙ ДУРСАМЖ

*Д.Баярхүү**

Судлаач профессор, дипломатч, Монгол Улсаас АНБЕУ-д суугаа Элчин сайд Д.Баярхүү “НЕРКО publishing” хэвлэлийн газартай гэрээлээд “БИ: Миний амьдралын тойрог” хэмээх дурдатгал номоо бичээд дуусч байна. Уг ном дахь Монгол-Хятадын хил шалгасан тухай хэсгээс нь дор сийрүүлж уншигчиддаа сонирхуулья.

Хил дээр & Сумласан гар буу цүнхэлж хил давав

Би бол 1982 оны зун Дорноговь, Сүхбаатар аймгийн хилийн участкаар (Хилийн цэргийн 12 ба 17-р отрядын хариуцсан хэсэг) аялаж, Монгол-Хятадын хил хамтран шалгах их ажлыг нугалалцсан хүн юм.

Түүх сөхвөл Ю.Цэдэнбал тэргүүтэй Монголын төлөөлөгчид Хятадад айлчлах үеэр хоёр орны хилийн гэрээнд Ю.Цэдэнбал, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Эньлай нар 1962.12.26-нд гарын үсэг зурж, гэрээний батламжийг 1963.03.25-нд Улаанбаатар хотноо солилцож, улмаар уг гэрээг 1975.10.05-нд НҮБ-д бүртгүүлснээр манай улсын өмнөд хил олон улсын хэмжээнд баталгаажсан байдаг.

Гэрээний дагуу хилийн шугамаа 1963 онд тогтоогоод дөнгөж дуустал Хятадын “Соёлын хувьсгал” дэгдээд хил манатай юм болоо биз. Тэгж тэгж 20 жилийн дараа хамтарч хилээ шалгах, тодотгох тохиролцоонд хүрч, Монгол-Хятадын хил шалгах ажил хийгдэх сураг 1982 оны хавар дуулав.

Шалгах ажлын ихэнхийг хил дээр хийх хээрийн ажил эзэлнэ. Энэ ажилд дайчлах хүн хүч, техникийг бүртгэж бүрдүүлж байх үед юмдаг, үүнд оролцвол баараггүй хийгээд өгье гэж миний дотно нөхөр ахмад Л.Төмөрбаатар (цэргийн байр зүйн) хэллээ. Би ч явахын түүс “За” л гээ биз. Жанжин штабын цэргийн байр зүйн албаны дарга дэд хурандаа Л.Лувсан гуай намайг дэмжиж БХЯ-наас тодорхойлж нэр оруулжээ. Ингээд дээд байгууллагын шийдвэр гарч би явлаа даа.

Бид Хилийн ба дотоодын цэргийн штабт цугларч хэд хоног семинараж, хятад хэлний хичээл хийв. Ингээд намайг Монгол-Хятадын хил шалгах 6-р салбар комиссын 12-р ажлын хэсгийн

* Д.Баярхүү - Монгол Улсаас АНБЕУ-д суугаа Элчин сайд, судлаач профессор, дипломатч

орчуулагчаар томилж, 1982.05.30-наас 1982.12.31-нийг хүртэл хүчинтэй тусгай үнэмлэх шийтгэн олгожээ. Хятадын талаар судалгаа, сөрөг сурталчилгааны өгүүлэл олныг бичсэн, тэгээд ч Улаанбаатар дахь Хятадын ЭСЯ-ныханд нүдлэгдчихсэн тул овог нэрээ солиод яв гэсэн чиглэлийг НАХЯ-наас өгүүлжээ. Би тэр дор нь “Дарьсүрэнгийн Дэмбэрэл” нэрээр үнэмлэхээ хийлгэж аваад, 5 дугаар сарын 20-доор тэр нэрээрээ Сүхбаатар аймгийг зорив.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан дахь Хилийн цэргийн отрядад манай 6-р салбар комисс байрлах тул тийшээ очиж газар орон дээр семинардах юм гэнээ. Хаврын урь орж эхэлж байсан, гэвч задгай машин дээр хүйтэн, ядаж байхад хүйтэн ундаа аваад уучихсан чинь замдаа хоолой өвдөөд ханиад хүрээд хүндрээд очжээ. Семинартаа ч суусангүй отрядын эмнэлэгт хэвтэж эмчлүүлэв. Манайхан дахин 10-аад хоног семинарджээ. Би сум, отрядтай танилцаж, Чоно голын нүүрсний уурхайн цооногийг үзэж амарч сэлгүүцэж өдрийг барах ажилтай. Отрядын улс төрийн хэлтсийн дарга Гончигдорж гэж айхтар идэвхтэй нөхөртэй танилцаж, бид хожим дотно болсон юм. Ингээд 5 дугаар сарын сүүлээр ажиллах участка руугаа салж явлаа. Биднийг авахаар Дорноговийн Улаан-Уул дахь Хилийн 12-р отрядаас ачааны бүрхүүлтэй ГАЗ-66 ирүүлжээ. Жолооч нь Ч.Эрдэнэчулуун гэж нэг улирсан ахлагч байна. Надтай чацуу юм. 12-р ажлын хэсгийн дарга нь Ж.Нарангэрэл гэж хилийн цэргийн залуухан дэслэгч байна. Орлогч нь М.Гончиг гэж геодезийн техникч, түүний туслах нь Д.Намхайдагва, хэсгийн нарийн бичгийн дарга нь Т.Цэрэндаш гэж ПДС-ийн оюутан, тэгээд би, бидэнд үйлчлэх тасаг цэргийн даргаар манай найз Т.Алдар нэмэгдээд бид нэг баг болов. Насаар эрэмбэлвэл хамгийн ахмад нь Гончиг, жолооч бид гурав. Бусад нь дүү залуус байна. Бид зууртаа Сүхбаатар аймгийн Онгон сум дахь Хилийн 17-р отрядад хоноглоод, цааш давхисаар Замын-Үүдэд ирлээ. Хил шалгах 6-р салбар комиссын дарга хошууч Гантөмөр гуай ч хамт ирлээ. Бидний ажлыг эхлүүлээд, зааварлаад буцах юм гэнэ.

Манай хэсгийн үүрэг бол энэ 17, 12-р отрядын хариуцдаг хилийн 397 км 47 метр урт шугамын дагуухи 344-403 дугаар хилийн тэмдэгтүүдийг баруунаас зүүн тийш ажиллах дэс дарааллаар шалгаж геодезийн үүднээс баталгаажуулж, шинээр нэмэлт тэмдэгт зоох, хуучин 1960-аад оны тэр тэмдэгтүүдийг сэлбэх, хилийн шугамыг тодотгон, зарим газар тогтоох явдал байлаа. Энэ лут үүргийг нэр бүхий хэдэн залуу хийж гүйцэтгэх ажээ.

Амны нь салиа арилагүй хэдэн бандид ийм хүндтэй үүрэг ногдуулсныг бодохул нэг бол бидэнд хэт итгэсэн байх, эсвэл боловсон

хүчин олдоогүй байх, бүр муугаар бодвол “Муусайн хятадтай яасан ч яадаг юм” хэмээн хайнга хандсан ч тал байх шиг.

Анхны уулзалт Эрээнд болох тул бид айхтар шахуу ажиллав. Гантөмөр дарга дэргэдээс салдаггүй. Мөн 12-р отрядын тагнуулын дарга, отрядын сургагч орос хурандаа ирчихсэн зааварлаж байнаа. Ингээд ахмад туршлагатай Жүкээ гэдэг ахлагчаар УАЗ 469-өө жолоодуулаад 6 дугаар сарын 3-ны нэг бүрхэг өглөө улсын хил давав аа. Манай Гантөмөр даргын зааварлах нь дэндээд маш ноцтой ажлыг надад даатгачихжээ. Очоод хэрэг бишидвэл шууд хэрэглээрэй, хэрэг болж магадгүй гэж ятгасаар байгаад сумлачихсан макаров гар буу бичгийн цүнхэнд хийгээд Хятадын хил давуулчихжээ. Насаар ахмад нь, цэргийн хүн гээд надад нөгөөхөө бариулчихав. Байтагийн тулалдааны үед бичиг хүргэхээр явсан Бадамыг хасагууд барьж үлдээд алдаг үйл явдал давтагдана гэж хилийн цэргийн ахмад дайчин Гантөмөр бодож л дээ. Төсөөлбөөс би Эрээнд очоод нөгөө гар буугаа гаргаад хэдэн хятадыг буудаж алаад эцэст нь өөрөө алуулж “БНМАУ-ын Баатар” цолоор нэхэн шагнуулах ухааны юм толгойд нь орж ирснээс гарцаагүй боллоо.

Бид ч БНХАУ-ын нутаг хөл тавилаа даа. Жүкээ нь хилийн уулзалтаар өмнө нь ирж байсан тул биднийг бодоход юм үзэж нүд тайлсан. Бид нэг том навсгар тосгон руу яваад орлоо. Тэр үеийн Эрээн нь уртаашаа 10 гаруй мянган хүнтэй, ганцхан буудалтай, нэг өндөр хоршоотой, км хүрэхгүй нэг өргөн чөлөөтэй, хүмүүс нь давсны үйлдвэр, төмөр замд ажилладаг, бараг балгас болох шахсан тосгон байв. “Гадаад Монгол”-оос хааяа нэг очих албаны хүмүүсийг эвэртэй туулай үзсэн мэт дагаж хуйлардаг (“Сэрэлт” киноны орос эмчийг нутгийнхан хэрхэн хүлээн авдаг тэр дүр зураг) байж билээ.

Амны нь салиа арилаагүй шахуу 5 банди наанаас нь яваад очиж байдаг, гэтэл цаана нь хэн угтсан гээч. Хятадын талын дарга нь Өвөр Монголын Зүүн Сөнөд хошууны засаг дарга Ли Бао (Үүрийн-Эрдэнэ) гэж 46 орчим настай кадр байна. Өвөрмонгол хүн гэнэ. Орлогч нь Хятадын хилийн цэргийн ахлах офицер Раашдаваа гэж 49 настай ахимаг эр байна. Тэр үед хятадын арми цэргийн цолоо устгачихсан, цэрэг офицergүй адилхан формтой байсан тул цэргийн хүн л гэхээс цолыг нь ёстой бүү мэд. Тэрээр Эрээн дэх Хилийн ерөнхий ертөөний хилийн төлөөлөгчийн орлогч, Эрээнд насыг барж байгаа хүн гэнэ. Геодези-техникийн асуудлыг Ли Зүньчи (36 настай, хятад) хариуцахаар Бээжингээс иржээ. Гишүүдэд Шилийн гол аймгийн гадаад харилцааны ажилтан

Журамт (46 настай), Эрээний Ерөнхий өртөөний хилийн төлөөлөгч Гао Вэньбү буюу Гомбо (40 гарсан), Эрээний Ерөнхий өртөөний хилийн офицер Хасбаатар (30 настай), комиссын нарийн бичгийн дарга нь Эрээний олон улсын зочид буудлын гадаад харилцааны ажилтан Лю Симин (40 настай, хятад), Хөх-хотоос Засгийн ордноос ирсэн Ван Чуанжин (39 настай, хятад), хожим миний найз болсон Ли Фэнхуа (Тэгшдүүрэн, 30 настай), Байху (Шагаанбарс, 36 настай) гээд өвөрмонгол хэлмэрч нар, тэдний дундаж нас нь 40 орчим, цаана нь Лю Гуйцай, Ли Боган, Шэн Зянвэн гээд техникийн 3-4 хүн, нийлээд арван хэдүүлээ угтдаг байна шүү. Үнэхээр их бэлтгэж, их ч ач холбогдол өгчээ.

Хэлэлцээ хоёр өдөр дараалан Эрээний хилийн цэргийн байранд явагдлаа. Хоёр өдөр дайлууллаа. Нөгөө золигийн гар буу эхний өдөр намайг ихээхэн зовоож өнжлөө. Цүнхээ чангахан тавьчихад л буун дуу тас. Юу болж таарах вэ? Орой нь очоод нөгөө буугаа Гантемер даргыг ятган ятган байж буцааж өглөө. - Ер нь энэ тэнэг ажлаа зогсоо, Хятадын нутагт орж буудалцана гэх наад тэнэг бодлоо сэтгэхүйгээсээ гаргаж хая гэж хэлж байж болиулж байгаа юм. Миний орчуулга гологдож байна. Анх удаа хил гарч, анх удаа хятад хүмүүсийн дунд орж байгаа юм чинь. Ойр зуур яриад, голыг нь манай Ли Фэнхуа, Байху нар, хоёр дахь өдөр манай талаас Хилийн цэргийн хэлмэрч Минжүүр нэмэгдэж нугаллаа. Харин бичиг баримтан дээр бол би сайн ажилласан. Би чинь гайгүй сайн уйгаржин бичигтэй тул хятадаар ойлгохгүйгээ тэдний таталснаас гаргаж уншаад хамтарсан баримт бичгийн төсөл (Анхдугаар хуралдааны протокол) гаргаад ирлээ. Хамтарсан хэсгийн хүлээх үүрэг, ерөнхий зарчим, ажлын журам, хийх ажлын дэс дараа гээд 6 бүлэг бүхий протоколд гарын үсэг зурав. Ингээд зуны 3 сард хилийн шугам дээр хийх ажлаа тохирч чадлаа.

Сониноос анх удаа тэнд дипломат хүлээн авалтад орж үзлээ. Бидэнд зориулж суугаа хүлээн авалт, бараг л дайллага хийлээ. Лав 20-30 төрлийн халуун хүйтэн хоолоор дайлж, нөгөө алдартай “Моутай” хэмээх тансаг ундаагаа сөгнөжээ. Хятадын Гуйжоу мужийн “Моутайжин” хэмээх худгийн усаар нэрдэг энэ архи эдүгээ дэлхийн хамгийн сайхан умдааны нэг гэдгийг би тэртээ 1982 онд ийнхүү мэдэж, амсаж, дурласан юм. Дайлуулсан биш эргээд хариу барих арга тактикаа ч давхар боловсрууллаа.

“Муусайн хятадтай яасан ч яадаг юм” хэмээн манайхан хайнга хандсан нь төсвөөс нь тодорхой боллоо. Бид 5-уул, тэд 10-уул, нийлээд 15-уулаа Монголд уулзаж таарна. Дараагийн

уулзалт манай нутагт болох ёстой. Гэтэл Сангийн яамнаас 10 хүнээр бодоод нэг хүний 30 төгрөг, нийт 300 төгрөг гэж нэг уулзалт, хүлээн авалтыг төсөвлөжээ. За байз, 1982 оны 30 төгрөгөөр чинь юу бүтээж болох билээ. Шил архи 26 төгрөг гэхээр их л мөнгө болж таарна. Нөгөө орос заншлаар 1-р хоол, 2-р хоол, салат, компот гээд гаргавал элбэг болох л доо. Эрээнд тэгж лут дайлуулчихсан улс чинь тиймхэн юм гаргах нүүр байсангүй. Ингээд би төсөв, ёслол, хүлээн авалтаа гартаа авлаа. Төсөв нөхөх элдэв аргыг ч сүвэгчиллээ.

Хил шалгах ажил маань Дорноговийн өмнөд хил дээр 1982.06.06-ны өглөө 09.00 цагт хилийн 344 дүгээр багана дээрээс эхэллээ. Бид говийн их халуунаас халшраад өглөө 07.00 цагт хээрийн ажлаа эхлээд 11.00 цаг гэж завсарлаад 16.00 цагт эргэж цуглаад орой 20.00 цаг хүргэх хуваарь мөрдөв. Тасаг цэрэгтэйнь тэднийгээ зарчихна. Майхнаа бариулаад мануулчихна. Тогоогоо бариулна. Газар шорооны ажлаа хийлгэнэ. Заставуудыг бараадаж байрлаад л. Алдар бид хоёр оройжин гитардаж уйтгараа тайлна. Би муу ВЭФ-ээ аваад явсных дэвэн дэлхийн мэдээ, FM сонсоод л. Говийн богино шөнө унтана гэж байхгүй шуугилдаад өнгөрдөгсөн. Бид Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх сумангийн байранд байрлаж байхдаа дандаа гадаа унтдаг байж билээ. Шөнө сар руу теодилит хэмээх дурангаараа дурандчихна. Үнэхээр сонин.

Хилийн цэрэг биднийг хүнсээр хангах үүрэгтэй. Хонь, ямаа амьдаар нь өгнө, гурил, будаа, гоймон, давс, масло, элсэн чихэр, хуурай цай, энэ хэд дээр л эргэлдээд байх нь тэр дээ. Гурилаар замбаа гэж хоол цэргүүд хийдэг тул өглөө болгон иднэ. Гурил хайрахыг л хэлдэг юм билээ. Надад нэг адтай санаа төрлөө. Төсөв хүрэхгүй шараа болж байхаар гээд мөнгө нөөцлөх хэрэгтэй гэж бодлоо. Яаж нөөцлөх вэ? Хонь, ямаагаа алж идэж байхаар Замын-Үүдийн хөдөлмөрчдөд аваачиж заръя гэж шийдлээ. Говиор нэг бэлчиж яваа зээр байна. Түүгээр махны хэрэгцээгээ хангая гэж би санал гаргалаа. Манайхан зөвшөөрч байна. Оройхон хэрд АК-нуудаа сумлаж аваад гарлаа даа. Нар шингэх үед хэдэн зуугаараа бэлчиж явдаг тул зээр намнахад тун хялбар. Ингээд л зээрийн махаар тансаглаж гарлаа. Хорхого хийж иднэ. Шарна, чанана, хоолонд хийнэ.

Тэр үед бид Замын-Үүдэд нэг хонийг 300 төгрөг, нэг ямааг 100 төгрөгөөр өгдөг байв. Ингээд 10 байтугай хүнийг хүлээн авах зардалтай болчихож байгаа юм. Хоёр дахь уулзалтыг бид хээр майхандаа авъя гэж шийдлээ. Замын-Үүдэд авахын тулд сайтар бэлтгэх хэрэгтэй тул хойшлууллаа.

1982 оны 6 дугаар сарын сүүлчээр болов уу. Хил дээр хээр майхнаа шаачихаад хивс дэвсээд газар суулгачихъя. Харин хонины хорхоогоо застав дээр хийгээд машиндаа ачаад очъё, тэр болтол зууш, архиараа дайल्या гэж би сценар зохиов. Хонины хорхоогоор очкоов авах санаатай. Замдаа сэгсчүүлээд очсон хорхоого янзтай болжээ. Говийн тарган ирэг байсныг хэлэх үү. Ингэж анхны даваагаа давлаа.

Гурав дахь уулзалт, хүлээн авалтыг хятадууд мөн л хил дээр хоёр гэр бариад лут хийж байна. Нэг гэрт нь найрлаад нөгөө гэрт нь кино тавьчихаж. Японтой дайтдаг эх оронч хүүхний тухай өвөр монгол кино байнаа. Өдрийн турш найрлалаа.

Бид үнэхээр гар нийлж ажиллаж байлаа. Монгол, хятадгүй эвсэг найрсаг. Дайсагнасан хоёр хөршийн дайсагнал ер ажиглагдсангүй. Хятад руу сэлэм далайж буу онилон, дайтаж ялна гэх сэтгэхүй надад хэзээ ч төрж байгаагүй, тэр үед тархинд бүр ч гүн суулаа. Гэхдээ харилцан бие биенээ турших, тандах, мэдээлэл цуглуулах юм байж л таарна.

Газар нутаг дээр зөрөлдөөн гарч байлаа. Замын-Үүдийн зүүгээр улсын хил гэнэт баруун хойшоо эргэсэн зурвас бий. Хилийн 363-370 дугаар тэмдэгтийн хооронд Их замын зүүн захаар Шар хадны булаг гэж үзэсгэлэнт баянбүрд тэнд байдаг юм. Тэр хэсгийг 1960-аад онд шалгаж тогтоогоогүй орхисноос үүдэн тэнд маргаан гарлаа. Зам нь тодорхойгүй болж, зарим хэсгээрээ балартаж, хилийн шугам хаана яваа нь ч мэдэгдэхээ больжээ. Бүтэн сар ажил гацаасан маргаан л даа. Манайхан хятадын нутаг гээд ойртдоггүй, хятадууд болохоор монголын нутаг гээд ойртдоггүй, онгон зэрлэг болсон газар бид 1982 оны 7 дугаар сард явж очиж байгаа юм. Хоёр гурван түүхэн овоо байна. Жинчид түүгээр явж Бээжин Да хүрээний хооронд жин тээдэг байсанаас “Их зам” гэж нэрийджээ. Маргаж маргаж ажил зогслоо. Бид ч төвдөө уламжиллаа. Би өөртөө томилолт гаргуулаад Улаанбаатар руу явлаа. Бараг гурван сар хотдоо очоогүй, гадаадаас ирж байгаа аятай, их өндөр сэтгэгдэлтэй галт тэрэгнээс буулаа. Бас гэрийнхэндээ бяцхан бэлэгтэй.

Хил шалгах төв комиссын зөвлөх Б.Цэдэн-Иш (НАХЯ-ны орлогч сайд, дэслэгч генерал, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин) Замын-Үүдэд очиж бидний зөвлөхөөр ажиллах болжээ. Төв комиссынхон ч Эрээнд уулзалт хийхээр Замын-Үүд рүү гарлаа. Би тэдэнтэй нэг цуваанд БХЯ-ны Л.Лувсан даргын УАЗ 469-д орчуулагч дипломатч Ө.Гүрсэд гуайтай хамтдаа явлаа. Хил шалгах төв комиссын дарга

нь ГХЯ-ны хэлтсийн дарга Г.Нямдоо гуай, би тэгэхэд сайн танилцлаа. Хилийн ба дотоодын цэргийн штабын дарга хурандаа Ж.Дашдаваа, хурандаа Санжаа, дэд хурандаа Дамчаабадгар, Ламжав, газар зүйн эрдэмтэн Ц.Бадамжав, Геодези зураг зүйн газрын дарга Рагчаа, бичээч Саранчимэг гэх мэт нэлээд олуулаа явсан юм. Хилийн ба дотоодын цэргийн штабын дарга явж байгаа юм чинь харьяа ангиуд нь хөл алдаад жигтэйхэн. Бид замдаа Мааньтын хорихоос мал хуй гаргуулаад хээр очиж найрлалаа. Морьтын хишиг явганд гэгчээр мань мэт л жаргаж явлаа. Орой нь Сайншанд орж буудалд хоноод өглөө эрт Улаан-Уул руу гарч өглөө. Замдаа манайхан тарвага агнаад Улаан-Уулын отряд орж боодог хийлгэв. Тусгай гэр бариулчихсан луг найрлаж байнаа. Отрядын дарга нь Доржсүрэн гэж хошууч, Улс төрийн хэлстийн дарга нь ахмад Бүлтэн, штабын дарга нь ахмад Дүүмаам бил үү, Хүүхэндүү бил үү нэг гялалзсан залуу байсан санагдана. Найрлаж найрлаж орой нар жаргах хирд Замын-Үүддээ ирлээ. Б.Цэдэн-Иш генерал өндөр настай хүн тул бидний аяг даахгүй гээд вагоноор иржээ. Тэр үед Бээжинд атташе байсан Х.Аюурзана мөн Хятадаас галт тэргээр ирсэн байв. Орчуулгад нэмэр болох зорилгоор Ө.Гүрсэд гуайн төрсөн дүү Ө.Дашдорж гуай (надтай хамт радиод ажиллаж байсан) салбарт комиссоос дуудагдан орон нутгаас бас иржээ. Тэр үед чинь Замын-Үүдийн ганц люкс буудал нь одоогийн ертөөний төв байрны арын ганц хоёр өрөөнүүд байсан юм. Тэр хэд өртөөн дээрээ байрлаад, хуралдаад, хүлээн авалтаа хийгээд, өртөөнөөсөө гарах шаардлагагүй. Бид Замын-Үүдийн шалганы өвлийн байранд байрлаж байв.

Комиссынхон Эрээн орж хуралдаад Шар хадны булгийн газар нутгийн маргааныг ингэж шийджээ. Тэр хэдэн түүхэн овоо бүхий газрыг бид өгнө. Харин Ховдын баруун хилээр өгсөн шигээ газар авна гэж. Чингэхдээ голын усны дундуур зааглана гээд заачихсан. Гэм нь говьд тэр гол нь ширгээд алга болчихсон. Гэхдээ гол байсан сайран дээгүүр бид хилийн шугамаа тогтоож, хилийн 363-370 дугаар тэмдэгтийн хооронд 20 туслах чанарын тэмдэг босголоо. Ингэхдээ 45 гаруй км урт хилийн шугамыг шулуун шугам болгож өөрчиллөө. Эртний жинчид хойноосоо ирээд гол гатлаад амрахдаа овоон дээр чулуу овоолсоор байгаад босгочихсон байж. Ингээд түүхэн овоонууд Хятадын газрын зурагт орлоо. Бүтэн сар ажил зогсоосон Шар хадны булгийн маргааныг дуусгасан тул бид хээр хятадуудтайгаа найрлалаа. Тэр үед л би хятад архины амт, ид шидийг мэдэрч дуртай болсон юм.

Ингээд хээрийн ажил цаашаа жигдэрлээ. Ноцтой маргаан гарсангүй. Гар нийлнэ гэж жигтэйхэн. Малын дайсан хоёр чоно баахан зээр хөөж явахтай бид гэнэт таарлаа. Ажлаа зогсооцгоогоод нэг чоныг нь бид хил рүүгээ оруулаад ГАЗ 66-гаараа элдлээ. Нөгөөхийг нь хятадууд хил рүүгээ оруулаад элдээд алга боллоо. Бид буутай яваагаа тас нуучихдаг байсан юм. Хээр, хил дээр ямар ч солиотой амьтан, хулгайч явах юм билээ. Халдлагад өртвөл яахав. Тэд ч том алчуураар боочихсон АК хэдтэй, бид бас 2-3 АК-тай. Ингээд чоно хөөгөөд хил рүүгээ орсон биш, бид АК-гаараа галлаад л, нөгөөдүүл хилийн цаана автоматын галаар пажигнуулж өгч байна. Тэд ч бид ч чононуудаа алсан даа. Бид ээлжилж буудаад, над дээр ээлж ирэхэд нь би хөлийг нь тас буудчихав. Ачааны машины явдал дунд мэргэн буудсан байгаа биз. Нөгөөх чоно чинь өрөөсөн хөлгүй ойчоод өгөв. Тоормосоо гишгээд гишгээд жолооч маань зогсоож чадсангүй, нөгөө чоноо дайраад гарав аа. Эргээд иртэл нөгөөх чинь өндийгөөд ирж байна. Ёстой хоншоортой амьтан юм аа. Манай тогооч цэрэг бууж очоод хулхин дундуур нь АК-дав. Орой нь чоноо өвчих юм болж өмхийгөөс нь айгаад цэргүүдээр жалганд аваачиж янзлуулав. Чоно алсан хийморьтой явдлаа тэмдэглээд хятадуудын өгсөн бэлгийн архи хувааж уув. Тэр чонын арьс, шагайг манайхан надад бэлэглэсэнийг би Замын-Үүдэд очоод Шалган нэвтрүүлэхийн даргад бил үү, нэгэнд нь бэлэглэчихсэн юм.

Бид 9 дүгээр сард Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт ажиллав. Зээр агнаж идээд л, хонь ямаагаа нөөцлөөд л, таргалуулаад л. Онгон суманд хилийн отрядын дарга нь Шинэжил гэж хошууч байсан санагдана. Манай хэсгийн дарга дэслэгч Нарангэрэл бол тэр отрядын офицер, нөгөө гар буу өгч Эрээнд томилдог Гантөмөр гуай ч мөн эндхийн ахмад хилчин. Онгон суманд хэл үггүй, маргаангүй сайхан ажиллаа. Шилийн богдыг ч очиж үзлээ. Эх орныхоо хилээр бүтэн 5 сар аялжээ. Надад бол үнэхээр дурсгалтай үйл явдал болжээ. Хилийн цэрэг, хил хамгаалахын талаар анхны “А”-тай болжээ.

Бид 9 дүгээр сарын 12 гэхэд хамтран шалгах хээрийн ажлаа дуусгаад Замын-Үүддээ ирлээ. Бид хамтран шалгах ажилдаа нийт 99 өдрийг зарцуулж, элдэв зүйлийн шалтгаанаар 46 өдөр саатаж, хил дээр нийт 53 өдөр ажиллаж, хуучин байсан хилийн 60 үндсэн тэмдэгтэд (багана) нэг бүрчлэн шалгалт хийж, сэлбэн засварлаж, 60 үндсэн тэмдэгтийн хооронд нийт 67 туслах чанарын багана хамтран босгожээ. Одоо бид хээр хийснээ,

тухайлбал хилийн шугамыг шалган тогтоож, шинээр нэмэлт багана тэмдэгтүүд босгосноо цаасан дээр буулгаж, эрх зүйн үүднээс баталгаажуулах ажлаа дуусгахаар сууж ажиллана.

Замын-Үүдэд хилийн том хаалга бий, түүний хажууханд ижил дугаартай хосоор босгосон төрийн сүлдтэй хилийн 357 дугаар багана байгаа. Тэр баганын хажууд хээрийн майхан (палаатак) барьж аваад конторлов. Хилийн протоколыг монгол, хятадаар бичнэ гэсэн үг. Намрын сэрүү орчихсон, бид бээвийтэл сууж байгаад дуусгасан даа. Энэ ажлыг гардан хийх үүрэг над дээр буулаа. Хятадын талын Раашдаваа гуайтай хамтран хийсэн гол ажил маань энэ байлаа.

Ажлаа дүгнээд Замын-Үүд, Эрээнд харилцан хурал зохион байгуулах ёстой. Анх Эрээнд эхэлсэн бол Эрээнд (Нийт 5 удаа хуралджээ. Хятадын талд 3 удаа, Монголын талд 2 удаа) төгсгөж салсан юм. Түүний өмнөхийг бид урьж хийх учиртай. Үүн дээр нөгөөх ёслолын ажлынхаа хур туршлагыг би гаргалаа даа. Миний зохиомжоор болсон юм. Эхлээд хонь ямаануудаа зарж дуусгалаа. Манай мал тэмдэгтэй, хаана ч танигдахаар. Учир нь ачааны машины тэвшинд улаан тосон будаг (сүлд, дугаарын тоо буддаг) асгарчихсан тул бүгд улаан эрээн толботой. Тэр намар улаан тосон будаг түрхчихсэн баахан хонь ямаа Замын-Үүдэд зарсан юм. Хэрэв авч идсэнээ санаж байгаа хүн байдаг бол, тэгээд миний энэ номыг уншиж байгаа бол зарсан эзэн би байна л даа.

Гайгүй мөнгө хуримтлагдлаа. Тэр үед Замын-Үүд чинь хилийн тусгай бүс гээд хангалт сайтай, нийслэлд ховор бараа нэлээд байх. Ялангуяа архи умдааны төрлийнх. Шампанск, коньяк, төрөл бүрийн пиво. Бүгдээс нь авлаа. Ширээгээ дүүргэх, сонирхуулах зорилгоор. Хэд хэдэн төрлийн хоол хийхээр меньюг би зохиов. Бас л ширээ дүүргэхээр янз бүрийн зууш зохиомжлов. Замын-Үүдийн өртөөний байрыг эзэгнэлээ. Дарга нь юм шиг л би тэнд командлаад л, рестораныг нь ч би мэдэж хаалгаж нээлгэдэг боллоо. Цэрэг авчруулж гадуур нь харуул гаргаад, согтуучууд золбин иргэдийг хөөж явууллаа. Замын-Үүдийн ганц клубыг хаалгаж тусгай үзвэр бид зохион байгуулах болов. Бас л миний зохиомж. Сайншандаас кино авчруулсан чинь уран сайхны ганц ч монгол кино алга, тэр нь Улаанбаатараас ирдэг юм гэнэ. Дан баримтат кино, бас тэгээд Монгол-Зөвлөлтийн найрамдлыг баахан харуулжээ. Тэр нэг тиймхэн боллоо. Зөвлөлт, Хятад хоёр ид дайсагнаж байх үед. Гэхдээ үзүүлсэн болохоос аргагүй. Учир нь тэнд тэгж цаг нөгцөөхгүй бол ресторан дараагийнхаа хоолыг хийх цаггүй болчихно. Үдийн хоол идүүлж

дараа нь кино үзвэр, дэлгүүр энэ тэр гэж зугаацуулаад оройн хоолонд аваад ирье гэсэн хөтөлбөртэй.

Ингээд болсон өдрөө хил дээр бид тосч авав. Нөгөөдүүл чинь хоёр хятад ногоон жипээр дүүрэн, 10-уулаа чихчихэж. Монголын хил даваад монгол хотод анх удаагаа ирж байгаа. Бараг бүгдээрээ. Намрын сэрүүн орсон, салхитай, хуйсгануур, бүрхэг өдөр байлаа. Замын-Үүдийн өртөөний 1-р давхрын том зааланд хэлэлцээгээ эхлэв. Хээрийн ажил амжилттай явагдсаныг тэмдэглээд, түүнээ эрх зүйн үүднээс баталгаажуулах ажил, хилийн протокол бичилтийн явцыг харилцан ярилцав. Орчуулгын голыг Ли Фэнхуа нугалж, би оролцож, би бас тэмдэглэл хөтлөв. Үдийн өмнөх хуралдаан амжилттай явагдаж байтал өртөөний рестораны дарга намайг дуудуулж байна. Гараад очтол тог тасархчихсан, хоол түүхийрэх нь гэж байна. Тэр үед тог нь тасрахаар ус нь бас тасарчихдаг тул бүр хэцүүджээ. Жорлон, угаагуураас аваад монголын нэр төрийг хөөдөх юм мундахгүй. Тог яадаг юм гэсэн чинь Сайншандаас тог өгдөг, тэр нь алга гэж байна. Би ч яахав Сайншанд руу утас цохилоо. Эрчим хүчнийх нь албаны хүмүүстэй ярьтал төвийн эрчим хүчний системтэй ярь гэж байна. Үгүй ээ, энд ийм чухал уулзалт болж байна. Залгаад хүлээн авалт хийнэ, хамаг хоол түүхийрлээ гэсэн чинь “Муусайн хятадууд яадаг юм” гэсэн хариу хэлээд бараг намайг тавлаж байна. “Биш ээ, муусайн байх тусмаа бид эх орныхоо нэр хүндийг авч гарах хэрэгтэй!” гэж би байдгаараа хэлээд нэмэр алга. Тэгж тэгж “Тог өгнөө, хүлээж л байхгүй юу” гээд л утсаа тасалчихав. Би ч дор нь шийдвэр гаргалаа. Замын-Үүдийн өртөөний гадаа гурван том чулуу олж тавиад ил гал өрдөөд хоолнуудаа том тогоонд хийж авчраад буцалга, болго, харин хятадуудад харагдуулж болохгүй. Мэргэн шийдвэр байгаа биз, өөр яах юм, ямар тог тасарсан уучлаарай гээд тэднийг өлөн буцаалтай биш.

Тэгж тэгж хоол боллоо шүү. Би ч хэдэн удаа гарч гүйв, бүү мэд. Өртөөний рестораныг цэвэрлээд бэлтгэчихсэн, тэндээ гал дээр болсон хоолоор дайллага хийв. Архи дарсыг чамгүй гаргалаа. Сонголт ихтэй. Хятадууд маань жорлон ордог, усгүй, тэр нэг тиймхэн. Замын-Үүдийн барааны ганц дэлгүүрийг бэлтгүүлчихсэн байгаа. Хүний 20 төгрөг дугтуйлаад өгчихсөн. Бид цуваагаар дэлгүүр рүү хөдөллөө. Тэд манай дэлгүүрийг сонирхож байна, үзэж байна. Харин 20 төгрөгөөр юу ч авах билээ дээ.

Тэд гараад л ийш тийшээ хараад сонжоод байна. Нэг нь “Танай оросууд чинь хаана байна?” гэж асуудаг юм байна. Замын-

Үүдэд ганц ч орос байхгүй ээ гэлээ. Гайхаж байгаа гэж жигтэйхэн. Бодвол тэднийг баахан орос цэргийн дунд яваад орчихно, Монгол улс тэр чигээрээ оросжсон гэж Бээжингийн суртал нэвтрүүлэг цэнэглэсэн бололтой, ажаад байхад. Нөгөө надад цэнэгтэй гар буу өгч Эрээн рүү явуулсан, эдний байж байгааг, яг адилхан. Эд ч бас цэнэгтэй гар буу хаа нэг газраа нууж авч орж ирснээс зайлахгүй боллоо. Дайсагнал гэж нэг иймэрхүү л юманд хүргэнэ дээ хэмээн бодож, инээд хүрч суув. Хий дайсагналаас болж би дурсгалын ганц ч гэрэл зураггүй үлдсэн юм. Одоо их харамсдаг.

Хүсэн хүлээсэн тог маань Сайншандаас ирсэн мэдээ надад өглөө. Тэндээсээ клуб руу аваад явлаа. Тог ирээд удаагүй байгаа бололтой. Зэвхий харанхуй том танхимд бид хэдүүлхнээ баримтаг кино үзэв. Монголын урлаг, байгалийн тухай киног гайгүй сонирхож байна. Гурав дахь нь Эрдэнэтийн тухай, Монгол-Зөвлөлтийн найрамдлын тухай кино байна. Тэд ёстой нэг уйтгартай үзлээ. Эвшээлгээд л, хоорондоо ярилцаад л. Оросуудыг харах тусам зэвүү нь хүрч байгаа бололтой. Кино дууслаа. Оройн зоогондоо урилаа. Тог ирчихсэн, манай тогооч нар маадгар байна. Бүх юм жин тан. Оройн зоогийн үед шампанск буудуулж үзүүлээ. Хятадууд маань давхийтэл цочоод, хөөсөрсөн архи анх удаа ууж үзэж байгаа гэнэ. Хоёр дахиа задлах гэтэл нөгөөдүүл маань нүдээ тас аниад чихээ бөглөөд ширээний цаагуур нуугдаад, мөн инээдэмтэй явдал болж байнаа. Орос архи ууж үзлээ гээд л олзуурхаад ярилцаад байна. Орой бүрэнхий болсон хойно тэднийг сүлдтэй багана хүртэл гаргаж өгөв. Баганы дэргэд дахин архи задлав. Бүгдэд нь бэлэг өглөө. Савхин бээлий, түрийвч, өөр юу ч байлаа даа. Энэ бүхэн бүгд миний менежмент, миний дипломат ажлын дадлага байлаа. Хэрэв Сангийн яамны 300 төгрөгөөр аргал гэсэн бол яаж үхэх байсан бол оо?

Хэдэн өдрийн дараа 10 дугаар сарын 8-нд сүүлчийн уулзалтаа Эрээнд хийлээ. Тэр үеийн Эрээн бол одоо төсөөлөгдөхгүй л дээ. Уртаашаа ганцхан зочид буудалтай, тэр нь 3 давхар, хамгийн өндөр барилга нь тэр, нэг өндөр хоршоотой, км хүрэхгүй нэг өргөн чөлөөтэй, хүмүүс нь биднийг бүчиж аваад л, дагааж хуйлраад л, манай УАЗ-ыг тойрч шаваад л хачин утлаа. Дандаа ижил хувцастай, дарга цэрэг нь ялгагдахгүй.

Биднийг нөгөө ганц лут зочид буудалдаа хүлээн авлаа. Дугтуйнд 5 юань хийгээд хүн бүрийн өмнө тавьчихаж. Хил шалгах ажлаа харилцан дүгнэлээ. Ёслолын чанартай уулзалт, гарын үсэг зурах ёслол болов. Кино үзүүлээд яахав, харин Эрээн хотоор

зугаалуулъя гэж байна. Бид ч нөгөө мөнгийг нь халааслаад дагаад гарлаа. Эрээний дэргэд манай Замын-Үүд хамаагүй гэгээлэг харагдаж байв. Манай Замын-Үүд чинь дэргэд нь ёстой диваажин байсан байжээ. Үүнд үнэмших хүн одоо байдаг болов уу?

Бид хотоор аажуухан алхсаар нөгөө өндөр хоршоонд очлоо. Өндөр гэдэг нь хоёр давхар, дээрээ айл суудаг аятай. Харин бараа нь нүд унагахаар. Тэр үед монголчуудын үхэлддэг бүх юм байнаа. Тэр үед чинь монголчууд хятад халуун сав, будаатай шаазан, сумтай үзэг, торго, хилэн шаахай, нусны алчуур гэгсгээд цаашаа юу ч сонирхдоггүй байсан юм шүү дээ. Бид дор бүрнээ л наймаа хийлээ. Би өөртөө ба аавдаа тус бүр нижгээд үзэг, нүдний шилний гэр, нусны алчуур авсан санагдана. Шаазанг болохоор бэлэглэнэ бүү ав гэж хятадууд хэлж байна. Эргэж ирээд үдийн зоогондоо уригдав. Тэр маань үргэлжилсээр бараг орой болгосон байх. Дайлуулж дайлуулж орой хирд хилийн багана руугаа хүрсэн байх. Тэнд мөн манайхны жишгээр архи задалж, бэлгээ өгөөд биднийг баяртай гэх нь тэр.

Тэр үед хил дээр хамт ажиллаж явсан хятадын төлөөлөгчдөөс эдүгээ Ли Фэнхуа л надтай гэмгүй хэвээрээ. Тэр зун бид хоёр өөрийнхнөөсөө нуугдаж байгаад нөхөрлөлөө дурсаж байя хэмээн бугуйн цагаа солилцож билээ. Надад “Дорнын салхи” маркийн лут цаг өгснийг манай Л.Бэгзжав аваад үгүй хийсэн. Харин би гайгүй орос цаг өгсөн юм. Тэрээр Эрээний хилийн цэргийн ангид улс төрийн орлогчоор ахлах хурандаа цолтой (4 том таван хошуутай) ажиллаж байгаад чөлөөндөө гарсан. Намайг Эрээнээр явах тоолонд уулзаж дайлж зочилж байдаг дотно нөхөр минь юм. Бусад нь бүгд тэтгэвэртээ гарсан гэсэн байх.

Бид хилийн ажлаа бүрэн дуусгаад ажлаа Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан дахь хилийн отряд дээр салбар комисстоо хүлээлгэж өгөөд 1982 оны 10 дугаар сарын сүүлээр төрөлх хотдоо эргэн ирж билээ. Хил шалгах ажилд сайн зүтгэлээ гэж намайг НАХЯ-ны Сайдын сайшаалын үнэмлэхээр шагнасан юм даа. Түүн дээр хурандаа генерал С.Лувсангомбо гэсэн гарын үсэг бий. Тэр нь Батлан хамгаалах зөвлөлийн орлогч дарга байсан Лувсангомбо гуай шүү дээ.